

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Алтай хотын тохижилт үйлчилгээний газар ААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГАА-2024/09НА-СТА-ОНА

Цахим хуудас: www.audit.mn

Алтай хот

2024 он

Дарга, тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа

Утас: 99998431 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг

Утас: 99175677 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn

Ахлах аудитор: Э.Сүнжидмаа

Утас: 80048599 Цахим хаяг: Sunjidmaae@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт /Баталгаажсан хувийг оруулах/



ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

1402, Хөгжил хороолол, Жинст баг,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82099
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2024.03.14 № 114

танай _____ -ны № _____ -т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Алтай хотын тохижилт үйлчилгээний газар ААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийг эс зөвшөөрвөл Алтай хотын тохижилт үйлчилгээний газар ААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитаар босго үнээс дээш давсан дүнтэй авто сэлбэгийг бэлтгэхдээ худалдан авах ажиллагаа зарлаагүй, амралтын цалин давхардуулан олгосон, нэгээс дээш жилийн насжилттай авлагыг барагдуулах арга хэмжээ авч ажиллаагүй, дээд байгууллагын шийдвэрийн дагуу хөрөнгийг бүртгэлээс хасаагүй, байгууллагын зорилтод түвшинд өөрчлөлт оруулж дээд газраар батлуулаагүй зэрэг 114,150.1 мянган төгрөгийн зөрчил нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, УСНББОУС-1-тэй тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, тасалбар болголт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна

Асуудлыг онцолсон хэсэг

Хог нягтаршуулах үйлдвэрт хоёрдогч түүхий эдийг ангилан ялгаж, шахах боломжтой хог хаягдлыг шахан нягтаршуулан тээвэрлэх ажлыг эхлүүлж хуванцар гялгар цаасаар шон хийх төслийг Азын хөгжлийн банканд өгч санхүүжилтийг шийдвэрлүүлж туршилтын шатандаа байна. Шинээр хог түрэлтэд ажиллах хоёр автомашин үнэ төлбөргүй хүлээн авч ашиглаж байна.

Аудитын гол асуудал

Есөнбулаг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрээр татан буугдсан Алтай хотын Цогц үйлчилгээ УТҮГ-ын 3,654,679.2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэн авсан байна.

Бусад асуудлын хэсэг

0702900377

Есөнбулаг сумын Засаг даргын тамгын газраас байгууллагын даргын гүйцэтгэлийн төлөвлөгөөг 89.5 хувьтай үнэлсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Г.ГҮНЖИДМАА

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

/мян.төгрөгөөр/

Үзүүлэлт		2022.12.31	2023.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
Эргэлтийн хөрөнгийн дүн		77,722.2	110,657.1
Эргэлтийн бус хөрөнгийн дүн		9,083,206.6	9,774,267.4
Нийт хөрөнгийн дүн		9,160,928.8	9,884,924.5
Нийт өр төлбөрийн дүн			263.0
Цэвэр хөрөнгө/өмчийн дүн		9,160,928.8	9,884,924.5
Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн			
Үйл ажиллагааны орлогын дүн		2,801,797.9	6,029,832.7
Үйл ажиллагааны зардлын дүн		1,488,319.1	3,570,867.0
Үйл ажиллагааны үр дүн		1,313,478.7	2,458,965.7
Үйл ажиллагааны бус үр дүн		208,387.2	36,569.9
Үйл ажиллагааны нийт үр дүн		1,105,091.5	2,422,395.8
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
Дахин илэрхийлсэн үлдэгдэл		8,055,837.2	9,160,928.8
Тайлант оны үр дүн		1,105,091.6	2,422,395.8
Эцсийн үлдэгдэл		9,160,928.8	9,884,661.4
Мөнгөн гүйлгээний тайлан			
Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн		805,268.1	1,360,590.7
Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн		917,490.6	1,338,830.8
Үйл ажиллагааны ЦМГ		(112,222.6)	20,759.8
Хөрөнгө оруулалтын ЦМГ			
Санхүүгийн ажиллагааны ЦМГ			
Нийт цэвэр мөнгөн гүйлгээ		(112,222.6)	20,759.8
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		-	-
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн		1,258,000.9	1,339,830.8
Урсгал зардал		1,258,000.9	1,339,830.8
Хөрөнгийн зардал			
Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр		1,258,000.9	
Улсын төсвөөс санхүүжих			
Орон нутгийн төсвөөс санхүүжих		1,258,000.9	

Гурав. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 259,355.6 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын алдааг аудитын явцад залруулж, баталгаажуулав.

Залруулсан алдаа

- **Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой:** Санхүүгийн тайланд шүүхийн шийдвэрээр нөхөн тайлагнасан хувь хүний орлогын албан татвар 1,203.6 мянган төгрөг, нийгмийн даатгалын шимтгэл 1,545.3 мянган төгрөгийг, мөн 5,000.0 мянган төгрөгийн цалинг авлагаар, хувь хүний орлогын албан татвар 263.1 мянган төгрөгийг өглөгөөр, үр дүнгийн тайлан 18,648.8 мянган төгрөгийн зардлыг, мөн хөрөнгийн элэгдэл дутуу тооцсон 184,519.0 мянган төгрөг тайлагнаагүй нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-т "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр

дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;" заалтыг зөрчсөн байна

- **Хуультай холбоотой:** Бэлтгэн нийлүүлэгчээс нийлүүлсэн бараа ажил үйлчилгээний төлбөрийн дүн татварын нэвтрэлтийн нэгдсэн системд дутуу шивсэн 48,174.9 мянган төгрөгийг шивж залруулсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" заалт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;" заалтыг зөрчсөн байна

Залруулагдаагүй нийт 54,646.5 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс давсан байгаа тул "Хязгаарлалттай" санал дүгнэлт өгсөн.

Аудитаар 5 зөрчил илэрч, 1 зөрчилд төлбөрийн акт, 3 зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага, 1 зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

1. Амралт цалин давхардуулж 1,411.6 мянган төгрөгийн цалинг илүү тооцож олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Хөдөлмөрийн тухай хуулийн 110 дугаар зүйлийн 110.1-т "Ээлжийн амралтын цалинг ажилтны тухайн ажлын жилийн дундаж цалин хөлснөөс тооцож олгоно", Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/19 дүгээр тушаалын хавсралтын 3 дугаар зүйлийн 3.4-т "Ээлжийн амралтын цалинг тооцохдоо өмнө эдэлсэн ээлжийн амралтаас хойш ажилласан саруудын цалин хөлсний нийлбэрийг, тухайн саруудад ажилласан ажлын өдрийн нийлбэр тоонд хуваан ажлын нэг өдрийн дундаж цалин хөлсийг гаргаж ээлжийн амралтын өдрөөр үржүүлж бодно/- гэж заасантай нийцэхгүй, иж бүрэн байх, оршин байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон цалинг төлүүлж төсвийн орлого болгох төлбөрийн акт тогтоосон

5.2 Албан шаардлага

1. Жилийн эцсийн хөрөнгийн тооллогоор тооцоо бодоогүй, тооллогын комисс гарын үсэг зурж баталгаажуулаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна.", 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4-т "комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх/- гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэлт: Эд хөрөнгийн тооллогыг чанартай үр дүнтэй хийж, тооцоог бодож хэвших албан шаардлага хүргүүлсэн.

2. Нэг жилээс дээш насжилттай 27,913.1 мянган төгрөгийн авлага барагдуулаагүй нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах," Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.5-т "хуваарьт болон хугацаа хэтэрсэн өр төлбөрийг жилийн төсөвтөө бүрэн тусгаж өр төлбөр барагдуулах төлөвлөгөө, хуваарь баталж хэрэгжүүлэх" гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэлт: Авлагыг барагдуулах арга хэмжээ авч ажиллах албан шаардлага хүргүүлсэн

3. Дуудлага худалдаагаар зарагдсан 15,760.0 мянган төгрөгийн үнэ бүхий газар дансанд бүртгэлтэй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т "Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлнө", 14 дүгээр зүйлийн 14.4.2-т "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага/ гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэлт: Хөрөнгийг данс бүртгэлээс хасах албан шаардлага хүргүүлсэн

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Хууль тогтоомжтой холбоотой асуудал

Илрүүлэлт: Байгууллагын 2023 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түшингийн төлөвлөгөөнд өөрчлөлт оруулан эрх бүхий байгууллагаар шинэчлэн батлуулаагүй нь Хог нягтаршуулах үйлдвэрт хоёрдогч түүхий эдийг ангилан ялгаж, шахах боломжтой хог хаягдлыг шахан нягтаршуулан тээвэрлэх ажлыг эхлүүлж хуванцар гялгар цаасаар шон хийх төслийг Азын хөгжлийн банканд өгч санхүүжилтийг шийдвэрлүүлж туршилтын шатандаа байна. Шинээр хог түрэлтэд ажиллах хоёр автомашин үнэ төлбөргүй хүлээн авч ашиглаж байна/- эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Зорилтод түшингийн өөрчлөлт орсон үед зардлын эдийн үзүүлэлт бүрээр батлуулж байх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2024 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

/мянган төгрөгөөр/													
Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:						Зөвлөмж			
		Тоо	Дүн	Төлбөрийн акт	Албан шаардлага		Төлбөрийн акт		Тоо	Дүн		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн	
					Тоо	Дүн	Тоо	Дүн		Тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4		5	6	7	8	9	10	11	12	
Алтай хотын тохижилт үйлчилгээний газар ААТҮГ	Жилийн эцсийн бараа материалын тооллогоор тооцоо бодоогүй комисс гарын үсэг зурж баталгаажуулаагүй байна.	1	37,474.9	-	-	1	37,474.9	-	-	-	-	-	-
	Нэг жилээс дээш насжилттай 27,913.1 мянган төгрөгийн авлага барагдуулаагүй байна.	1	-	-	-	1	-	-	-	-	-	-	-
	Амралт цалин давхардуулж 1,411.6 мянган төгрөгийн цалинг илүү тооцож олгосон байна.	1	1,411.6	1,411.6	1	1,411.6	-	-	-	-	-	-	-
	Дуудлага худалдаагаар зарагдсан 15,760.0 мянган төгрөгийн үнэ бүхий газар дансанд бүртгэлтэй байна.	1	15,760.0	-	-	1	15,760.0	-	-	-	-	-	-
	Байгууллагын 2023 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түшигний төлөвлөгөөнд өөрчлөлт оруулан эрх бүхий байгууллагаар шинэчлэн батлуулаагүй байна.	1	-	-	-	-	-	-	1	-	-	-	-
Нийт		5	54,646.5	1,411.6	1	1,411.6	3	53,234.9	1	-	-	-	-

6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагы н нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн										Үүнээс:			
		Тоо	Дүн	Төлбөрийн акт	Албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллага д						
					Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн					
											Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12				
Алтай хотын тохижилт үйлчилгээний газар ААТҮГ	Худалдан авах ажиллагаа зохион байгуулалгүйгээр 59,503.6 мянган төгрөгийн сэлбэг хэрэгсэл худалдан авалт хийсэн.	1	59,503.6	-	-	1	59,503.6	-	-	-	-				
Нийт		1	59,503.6	-	-	1	59,503.6	-	-	-	-				